



ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2021 оны 10 сарын 14 өдөр

Дугаар 8/75

Ховд

Б.Гантөмөрийг шилжүүлэн томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.4, 33.5, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3, Төрийн албаны тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1 дэх заалт, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Төрийн албаны зөвлөлийн даргын 2019 оны 34/31 дүгээр хамтарсан тушаалаар баталсан "Төрийн жинхэнэ албан хаагчийг өөр албан тушаалд шилжүүлэх, сэлгэн ажиллуулах журам"-ыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн Хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан ахлах мэргэжилтэн Б.Гантөмөрийг Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн Иргэдийн өргөдөл, гомдол, эрэлт хүсэлтийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтнээр 2021 оны 10 дугаар сарын 18-ны өдрөөс эхлэн шилжүүлэн томилсугай.

2. Ажил хүлээлцэх ажлын хэсгийг хавсралтаар баталсугай.

3. Б.Гантөмөрийн сарын үндсэн цалинг Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан "Төрийн захиргааны албан тушаалын цалингийн сүлжээ"-ний ТЗ-6-5 дахь шатлал буюу 853375 төгрөг (найман зуун тавин гурван мянга гурван зуун далан тав)-өөр тооцож олгохыг Санхүү, аж ахуйн тасгийн ерөнхий нягтлан бодогч (Б.Нямдэлгэр)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА




Д.ЭНХБОЛД

02 0875

Tush B/75 Kh

100

Аймгийн Засаг даргын Тамгын газрын
даргын 2021 оны 10 дугаар сарын 14-ний
өдрийн Б/75 дугаар тушаалын хавсралт



АЖИЛ ХҮЛЭЭЛЦҮҮЛЭХ АЖЛЫН ХЭСЭГ

Ажлын хэсгийн

ахлагч: Б.Ганболд - Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга

Гишүүд: Х.Болормаа - Санхүү, аж ахуйн тасгийн нярав

Нарийн бичгийн

дарга: Б.Эрдэнэчимэг - Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн
мэргэжилтэн

-оОо-